

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЗАСГИЙН ГАЗРЫН
ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.ЭРДЭНЭЧИМЭГ

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт Улсын Их Хуралд 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу олборлосон газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд оруулахаар тусгасан байна. Мөн хуулийн төсөлд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас газрын тосны нөөц ашигласны төлбөрийг орон нутагт хуваарилахдаа олборлолт хийгдсэн тухайн орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээг бусад орон нутгийн нэг хүнд ногдох хэмжээнээс 10 дахин нэмэгдүүлж тогтоохоор тооцжээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд газрын тосны салбарыг хөгжүүлэх сангийн ангилалыг тодорхой болгон шинээр нэмж, газрын тосны салбарыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг газрын тос уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул хийх, газрын тос, уламжлалт бус газрын тосны салбарын үндэсний чадавхийг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээнд зарцуулахаар төслийг Засгийн газраас боловсруулжээ.


Дээрх хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх нь чуулганы нэгдсэн хуралдаанд оруулан хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар Төсвийн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ДАВААСҮРЭН